



**ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А190

Улаанбаатар хот

**“УБДС” ТӨХК-иас зохион байгуулж буй
ажил мэргэжлийн уралдаанд оролцох тухай**

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.11 дэх заалт, “ДЦС-2” ТӨХК-ийн Захиргаа, ҮЭ-ийн хороотой байгуулсан 2017-2018 оны Хамтын гэрээний 4.2 дахь заалт, “Улаанбаатар Дулааны Сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 10/438 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар Дулааны Сүлжээ” ТӨХК-ийн үүсгэн байгуулагдсаны 60 жилийн ойн хүрээнд Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд зохион байгуулж байгаа ажил мэргэжлийн уралдаанд тус компанийн баг тамирчдыг оролцуулсугай.
2. Ажил мэргэжлийн уралдаанд оролцох нэгдүгээр хавсралтад заасан нэр бүхий баг, тамирчдыг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 06 дугаар сарын 13-ны өдрийг дуустал ажлаас чөлөөлсүгэй.
3. Баг тамирчдыг тэмцээнд бэлтгэж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Хяналт техник, аюулгүй ажиллагааны хэлтэс /Г.Хүрэлбаатар/-т даалгаусгай.
4. Тус тэмцээний арга хэмжээнд зарцуулах зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
5. Төсөвт заасан 450800 /дөрвөн зуун тавин мянга найман зуу/ төгрөгийг зохих зардлаас гаргаж тооцохыг Санхүү, бүртгэл эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Б.Даваадулам/-д зөвшөөрсүгэй.
6. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс /Б.Гоёцэцэг/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.БЯМБААХҮҮ

Tushaal, 2019

360000587